



ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2017/120/СТА-ТТЗ

аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25 -нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 16-наас 2017 оны 03 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 20-нд Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль,НББ-ийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ. 40.2-д Төрийн өмчит бүх шатны сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын

тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч “ гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” 16 дугаар зүйлийн 16.4.18-д төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын ЕБСургуулийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг БСШУЯамнаас баталж, аймгийн ИТХ-аас батламжилснаар аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулийн зарим зүйл заалт хангалтгүй байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нийцлийн аудитын 4200–р стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд аудитын хяналтын болон нарийвчилсан 5 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулан мөрддөг. Сангийн яамнаас зөвшөөрөл бүхий Санхүүгийн тооцоолох ХХК-ний бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллага нь дотоод хяналтын

ажлын төлөвлөгөө тайлан ирүүлээгүй, ажиллаагүй. Иймд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Бүрэн сумын ЕБС-ийн 2016 онд батлагдсан төлөвлөгөө 613881.9 мянган төгрөгөөр батлагдсан ба санхүүжилтийг 100 хувь авсан. Аймгийн Засаг даргын 2016.12.23-ний өдрийн А/719 тоот захирамжаар хэмнэгдсэн зардлуудаас СӨБ, Соёлын төвийн өрийг барагдуулахад зориулан хөтөлбөр хооронд шилжүүлэн зарцуулах хуваарийг баталсны дагуу 8500.0 мянган төгрөгийг буцаан шилжүүлсэн. Аудитын явцад батлагдсан төлөвлөгөөг болон санхүүжилтийг 8500.0 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасан. Оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 935.7 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга бичилтээр тайлагнасан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 102385.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3340.9 мянган төгрөгийн төсөвт татан төвлөрүүлсэн.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар шилэн дансны хэрэгжилтэнд 2016 оны 10-р сарын байдлаар гүйцэтгэлийн аудит хийгдсэн. 2016 онд тус байгууллага нь шилэн дансанд 133 мэдээллийг хугацаанд нь оруулж, 16 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, тус байгууллагын санхүүгийн тайланд эхний 9 сарын байдлаар завсарын аудит хийгдсэн тул баримтыг шалгаагүй. Аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант оны батлагдсан төлөвлөгөөг тулган шалгахад батлагдсан төлөвлөгөөний дүнг нэмэлт санхүүжилтийн 102385.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийг татан төвлөрүүлсэн 935.7 мянган төгрөгөөр тохируулан тайлагнаагүй зөрчил илэрлээ. НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; Төсвийн тухай хуулийн 7.4.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана гэж заасантай болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

2. Санхүүгийн тайлангийн уялдааг тулган шалгахад санхүү үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдолын зардлыг өмнөх онтой харьцуулахад 81317.5 мянган төгрөгөөр илүү байгаа тул элэгдлийн тооцооллыг давтан шалгахад Дотуур байрны барилгын элэгдлийг 71443.9 мянган төгрөгөөр буруу тооцсон нь уг барилга 1978 онд ашиглалтанд орсон ашиглагдах хугацаа дууссан 2015 онд хийгдсэн их засварыг бүртгэхдээ барилгыг капиталжуулан бүртгэсэн боловч ашиглагдах жилийг сунгаагүйгээс элэгдлийг буруу тооцсон. НББ-ийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

3. Тогоочын хийсэн хоолны материалын захиалгын хуудасны хүүхдийн тоог хянадаггүй нотлох баримт байхгүй, хоолны эмч хянаж гарын үсэг огт зураагүй. 2016.12-р сарын 29.30.31-ний өдрүүдэд бүх хүүхдийг бүрэн байгаагаар бүртгэж, 391.2 мянган төгрөгийн хоолны зардал гаргасан нь төсвийг хяналтгүй зарцуулсан. Бусад хангамжийн материал дансанд 2016.09.22-нд 2000.0 мянган төгрөгийн үнэтэй аж ахуй гэсэн нэртэй хөрөнгө бүртгэсэн. НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Сангийн сайдын 2005 оны 276-р тушаалаар батлагдсан дансны нэгдсэн жагсаалтын заавар зэргийг хэрэгжүүлэн ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Дотуур байрны хүүхдийн тоог тогоочийн хоолны материалын захиалгын хуудастай өдөр тутамд тулган хянаж байх, Тогоочийн захиалгын хуудсыг хоолны технологийн карттай тулган хянаж анхан шатны баримтын бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт тавин ажиллах Бусад хангамжийн материал дансанд аж ахуй нэрээр бүртгэсэн 2000.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэр төрлөөр зөв ангилан бүртгэж хариуг ирүүлэх

4. НИК дундад бүс, Хархорин ЦШугам сүлжээ ХХК, шуудан үйлчилгээний газар, НДХэлтэс зэрэг 4 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан бусад байгууллагатай тооцоо нийлүүлээгүй байна НДХэлтэстэй тооцоо нийлэхдээ 29.1 мянган төгрөгийн авлагатай гэж нийлсэн боловч Төлөгч байгууллагын төлсөн дүн мөнгөн гүйлгээний тайлангаас НДХэлтэст төлсөн дүнгээс 282.8 мянган төгрөгөөр

зөрүүтэй авлагатай байна. НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасныг хэрэгжүүлэн ажилаагүй.

Шийдвэрлэсэн: Харилцагч байгууллагуудтай сар, улирлаар тооцоо нийлж, ажил гүйлгээг болон үлдэгдлийг баталгаажуулж ажиллах, НДХэлтэстэй зөрүүтэй тооцоо нийлсэн 282.8 мянган төгрөгийн тооцоог дахин хийж, авлага өглөгийг баталгаажуулах

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдсан алдаа байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацаанаас шалтгаалан завсарын аудит хийгдсэн тул анхан шатны баримттай тулган шалгах түүврийг хийгээгүй мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудлыг дараагийн аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 173828.9 мянган төгрөгийн, материаллаг бус 2674.0 мянган төгрөгийн буюу нийт 176502.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 173828.9 мянган төгрөгийн алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.
2. Материаллаг бус нийт 2674.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гарагхгүй байх зөвлөмж өгсөн

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь гаргаж ирүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна. Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ